



## Суралцагчийн хувийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах заавар

1. Ахисан түвшний сургуулийн цахим хуудас руу <https://gradschool.num.edu.mn/> хаягаар орно.
2. Цахим хуудсан дээр (Зураг 1) “Суралцагчийн хувийн төлөвлөгөө” цэсэн дээр дарна.



Зураг 1. АТС-ийн цахим хуудасны цэснүүд

3. “Суралцагчийн хувийн төлөвлөгөө”-ний үлгэрчилсэн загваруудаас (Зураг 2) суралцах түвшин, чиглэлд тохирох загварыг татна.



Зураг 2. Суралцагчийн хувийн төлөвлөгөөний загварууд

4. “Суралцагчийн хувийн төлөвлөгөө”-ний үлгэрчилсэн загварын excel файлыг нээж бүрэн гүйцэд бөглөнө. Файлын эхний хэсэгт (Зураг 3):
1. **Огноо:** Суралцагчийн хувийн төлөвлөгөөг бөглөсөн өдрөөр он, сар, өдрийг заавал бичнэ.
  2. **Бүрэлдэхүүн сургуулийн нэр:** Тухайлбал: Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны Салбар. ШУС-НУС, ХЗС гэх мэт товчлол хэрэглэхгүй. Тэнхимийг бичих шаардлагагүй.
  3. **Суралцагчтай холбоотой мэдээлэл:**
    - Мэргэжил: Хөтөлбөрийн нэрийг бичнэ. Тухайлбал: Боловсрол судлал, эрхзүй, менежмент гэх мэт. Эрхзүйч, химич гэх мэт бичихгүй.
    - Мэргэжлийн индексийг заавал бөглөнө. Тухайлбал: Судалгааны магистрын “Маркетинг”-ийн хөтөлбөрт сурч байгаа бол E 04140101 гэж бичнэ.
    - Элссэн он: 2019 он (Хавар), 2020 (Намар) гэх мэт элссэн он, улирлыг бичихийг зөвлөж байна.
    - ID: Суралцагчийн хувийн дугаар буюу Сиси ID заавал бичнэ.
    - Суралцах хугацаа: магистрын хөтөлбөрийн үргэжлэх хугацаа буюу 1,5-2 жил гэж бичнэ.
    - Суралцах хэлбэр буюу өдөр, орой, эчнээ гэх мэт бичнэ. Цахим, танхим, хосолсон гэх мэт бичихгүй.

Баталсан:	Н.Баатарбилэг, Ахисан түвшний сургуулийн захирал	Он, сар, өдрийг бичнэ.
		20.... он .... сар .... өдөр
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ</b>		
<b>БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ</b>		
<b>СУРАЛЦАГЧИЙН ХУВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>		
	Суралцаж буй БС-ийн нэрийг бичнэ.	
	Суралцагчийн мэдээллийг бөглөнө.	
	Судалгааны магистрант/докторант: ..... овогтой .....	
Мэргэжил:	ID:	
Мэргэжлийн индекс:	Суралцах хугацаа:	
Элссэн он:	Суралцах хэлбэр:	
	Нийт багц цаг:	

Зураг 3. Суралцагчийн хувийн төлөвлөгөөний Суралцагчийн мэдээллийн хэсэг

5. Файлын хүснэгт хэсэгт (Зураг 4):

- Сургалтын багц цагийг (А, Б) **Сургалтын мэдээллийн системд (Сисид) “Хувийн суралцах төлөвлөгөө”-нд** төлөвлөсний дагуу бичнэ. Дараа нь системд хичээл сонголтод өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд Суралцагчийн хувийн төлөвлөгөөг дахин хийх шаардлагагүй.

Д/д	Хичээлийн индекс	Хичээлийн нэр	Багц цаг	Улирал
<b>А. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ</b>				
А1. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ				
1	1			
<b>А2. МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛ</b>				
2	2			
3	3			
4	4			
<b>Б. МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛ</b>				
Б1. МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМЭС				
5	1			
6	2			
<b>Б2. БУСАД ТЭНХИМ, САЛБАР НЭГЖ</b>				
7	1			
8	2			

Сургалтын (А,Б) багц цагийг төлөвлөх

Зураг 4. Суралцагчийн хувийн төлөвлөгөөний хүснэгт

Магистр, докторын сургалтын хөтөлбөрийг Сургалтын мэдээллийн систем (Сиси) рүү нэвтэрч **эсвэл** дараах холбоосоос үзнэ үү.

- Судалгааны болон мэргэжлийн магистрын хөтөлбөрүүд  
<https://www.num.edu.mn/home/program.htm?alev=3&schID=99>
- Докторын хөтөлбөрүүд  
<https://www.num.edu.mn/home/program.htm?alev=4&schID=99>

6. Удирдагчтай багштай зөвлөсний дагуу, Эрдэм шинжилгээний ажлын (ЭША) (Зураг 5) багц цагийг (В) **МУИС-ийн Магистрант, докторантын эрдэм шинжилгээ, дадлагын ажлын багц цаг тооцоход баримтлах түр журмын** дагуу II улирлаас эхлэн жигд хуваарилж төлөвлөнө. Тухайлбал магистрын ЭША-ын 4 багц цагийн ажлыг төлөвлөхдөө:

ЭША-ын (В) багц цагийг удирдагч багштай зөвлөж, улирал бүрт жигд хуваарилж төлөвлөнө.

31	<b>В. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ</b>			<b>4</b>	
9	1		Эрдмийн зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	3	IV
10	2		Тэнхимийн эрдэм шинжилгээний төлөвлөгөөт семинарт илтгэл хэлэлцүүлэх	1	II
33					

Зураг 5. Суралцагчийн хувийн төлөвлөгөөнд ЭША-ыг төлөвлөх

7. Удирдагч багштай зөвлөж, магистрын ажил/диссертацийн сэдвийг (Г) (Зураг 6) заавал бөглөнө. Урьдчилсан сэдэв байж болно. Аль улиралд гүйцэтгэх хугацаа бичих шаардлагагүй.

Г. МАГИСТРЫН АЖИЛ		9
Магистрын ажил:		
НИЙТ БАГЦ ЦАГ		

Зураг 6. Суралцагчийн хувийн төлөвлөгөөнд магисрын ажлын сэдвийг төлөвлөх

8. Гарын үсэг зурж, баталгаажуулах (Зураг 7)



Зураг 7. Суралцагчийн хувийн төлөвлөгөөг хянах, баталгаажуулах

**Анхаарах зүйлс:**

- “Суралцагчийн хувийн төлөвлөгөө”-г МУИС-ийн сургалтын журам, эрдэм шинжилгээний багц цаг тооцох журам, магистр, докторын сургалтын төлөвлөгөөг сайтар уншиж танилцсаны дараа бөглөнө.

Холбогдох журмыг дараах линкээс үзнэ үү.

[https://graduate.num.edu.mn/?page\\_id=350](https://graduate.num.edu.mn/?page_id=350)

- Магистрын ажил/диссертацийн удирдагч болон тэнхимийн эрхлэгчийн аль сургууль, тэнхим, зэрэг цол зэргийг тодорхой бичнэ.
- Батлагдсан болон албан ёсоор төлөвлөгдсөн эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг, хурал зэргийг эрдэм шинжилгээний багц цагт төлөвлөнө. Тухайлбал тэнхимийн ажлын төлөвлөгөөнд батлагдсан тэнхимийн хэлэлцүүлэг болон эрдэм шинжилгээний хурал байна.
- Гадаад, дотоод монографийг эрдэм шинжилгээний багц цагт тооцохгүй.

**Зөвлөгөө авах бол дараах хаягаар холбогдоно уу**

E-mail: [grad\\_edu@num.edu.mn](mailto:grad_edu@num.edu.mn); [grad\\_research@num.edu.mn](mailto:grad_research@num.edu.mn)

Утас: 77307730-4501; 4502

**АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ**